ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Орхон аймгийн Уран-Эгшиг сургууль 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ОРА-2026/039/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Мөнгө нөөц баялаг Аудит ХХК-ийн аудитор Б.Байгал

Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.16 № 60

танай ____________-ны № ____________-т

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН УРАН-ЭГШИГ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.ТӨГСЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Ерөнхий боловсролын Уран-Эгшиг сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалтай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал,тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үүнд:

1. Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний нэр төрлийн тогоочийн тайлан гаргалгүйгээр худалдан борлуулах зорилгоор 28,004.8 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 45,946.3 мянган төгрөгийн хоол борлуулсны орлогыг харилцах дансандаа төвлөрүүлсэн,
2. Сургуулийн захирлын 2024 оны А/36 тушаалаар батлагдсан "Төрөлжсөн сургалтын журам нэмэлт зардлыг батлах" журамд элсэлтийн хураамж авах заалт тусгаагүй байхад элсэлтэд оролцож байгаа 146 иргэнээс 1,710.0 мянган төгрөгийн хураамж авсан,
3. Бага ангийн 8 багш, 1 хоол зүйч хоолны нөхөн олговор авсан хэдий ч 2,675.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоолонд хамрагдсан,
4. Тайлант онд 17,183.0 мянган төгрөгийн хөгжмийн хэрэглэгдэхүүн, бараа материалыг гэрээ байгуулалгүй, 29,754.1 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг, хувцас хэрэгслийг хүлээн авсан акт үйлдээгүй нийт 46,937.1 мянган төгрөгийн худалдан авалтыг шилэн дансны нэгдсэн цахим

012505368

хуудсанд мэдээлээгүй,

5. Жилийн эцсийн санхүүгийн тайланд 15,982.2 мянган төгрөгийн байгууллагат төлөх өр төлбөр, хувь хүнтэй холбоотой 180.3 мянган төгрөг нийтдээ 16,162.5 мянган төгрөгийн өр үүсгэсэн,
6. Тайлант онд 81 хүүхэд 13,400.0 мянган төгрөгийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлж, төлбөрийн орлогыг орлогод авахдаа хөнгөлөлтийг хассан дүнгээр орлого авснаас хөнгөлөлтийн дүнг зардлаар бүртгээгүй,
7. Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд аудитын иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн цайны газарт хоол үйлдвэрлэж, 45,946.2 мянган төгрөгийн орлого олсон байна. Бага ангийн сурагчдын үдийн хоол хийхэд шаардагдах хүнсний бүтээгдэхүүнийг тайлант онд борлуулсан хоолны түүхий эд материалтай цуг худалдан авч, 1 агуулахад заагаалгүй хадгалж, зарцуулж байгаа нь бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Орхон аймгийн Ерөнхий боловсролын Уран-Эгшиг сургуулийн санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **439,205,751.69** | **538,099,876.49** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 288,967,573.03 | 211,174,246.83 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 288,967,573.03 | 211,174,246.83 |
| **3121** | **Төгрөг** | 288,967,573.03 | 211,174,246.83 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 288,967,573.03 | 211,174,246.83 |
| **33** | **АВЛАГА** | - | 81,975,000.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 81,975,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 150,238,178.66 | 244,950,629.66 |
| **351** | **Түүхий эд материал** | 137,917,918.46 | 199,554,965.46 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 137,917,918.46 | 199,554,965.46 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,320,260.20 | 45,395,664.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,064,000.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,270,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | 2,952,180.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,986,260.20 | 42,443,484.20 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,588,232,580.10** | **4,607,768,905.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,588,232,580.10 | 4,607,768,905.32 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,190,186,017.60 | 4,209,848,905.32 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,689,663,063.00 | 3,818,646,463.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (185,708,304.19) | (270,541,076.84) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | 33,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (22,680,000.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 536,005,805.74 | 659,148,705.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (160,564,232.21) | (283,278,068.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 370,068,413.06 | 393,341,113.06 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (135,496,053.60) | (185,769,550.98) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 85,078,950.00 | 86,778,950.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (8,861,624.20) | (19,397,629.52) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 398,046,562.50 | 397,920,000.00 |
| 39301 | Програм хангамж | 675,000.00 | 675,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (548,437.50) | (675,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 397,920,000.00 | 397,920,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,027,438,331.79** | **5,145,868,781.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,396,504.00** | **58,507,408.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 8,396,504.00 | 58,507,408.00 |
| **413** | **Өглөг** | 8,396,504.00 | 58,507,408.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 15,982,200.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 8,396,504.00 | 42,525,208.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 8,396,504.00 | 42,344,908.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 180,300.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,019,041,827.79** | **5,087,361,373.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,019,041,827.79 | 5,087,361,373.81 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 397,920,000.00 | 397,920,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,621,121,827.79 | 4,689,441,373.81 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,621,121,827.79 | 4,642,370,123.79 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 47,071,250.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,027,438,331.79** | **5,145,868,781.81** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,045,440,756.64** | **2,668,870,523.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **305,159,356.64** | **537,724,623.49** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 305,159,356.64 | 537,724,623.49 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 305,159,356.64 | 537,724,623.49 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 162,477,200.00 | 258,580,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 137,971,460.64 | 279,144,523.49 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,710,696.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,740,281,400.00** | **2,131,145,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,617,317,500.00 | 2,024,948,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,617,317,500.00 | 2,024,948,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 122,963,900.00 | 106,197,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 122,963,900.00 | 106,197,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,074,591,053.09** | **2,824,713,560.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,074,591,053.09** | **2,824,713,560.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,010,682,240.61 | 2,748,881,394.34 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,404,451,105.24 | 1,979,900,864.04 |
| 210101 | Үндсэн цалин | 881,165,969.07 | 1,035,569,443.59 |
| 210102 | Нэмэгдэл | 456,542,028.97 | 823,247,657.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 54,111,071.98 |
| 210104 | Урамшуулал | 66,743,107.20 | 66,972,690.84 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 171,083,012.59 | 238,220,045.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,336,561.83 | 162,142,169.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,686,836.69 | 19,140,621.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,843,211.35 | 9,602,192.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,843,211.35 | 9,467,012.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,373,191.37 | 37,868,048.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58,100,787.52 | 75,771,333.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,337,360.38 | 40,373,549.47 |
| 210302 | Түлш, халаалт | 32,156,433.99 | 23,159,373.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,606,993.15 | 12,238,411.06 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,656,976.00 | - |
| 210408 | Бараа материал актласны зардал | 1,656,976.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 33,296,785.00 | 18,639,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,296,785.00 | 18,639,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 45,968,100.00 | 23,727,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,968,100.00 | 23,727,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,970,954.08 | 29,435,635.63 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 5,374,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,970,954.08 | 24,060,935.63 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 284,154,520.18 | 383,186,915.78 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 79,144,763.00 | 104,097,261.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,284,800.00 | 12,312,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 192,724,957.18 | 266,777,354.78 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 63,908,812.48 | 75,832,166.13 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,045,700.00 | 75,056,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,390,500.00 | 75,056,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,655,200.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 863,112.48 | 775,666.13 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 863,112.48 | 775,666.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(29,150,296.45)** | **(155,843,036.98)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(29,150,296.45)** | **(155,843,036.98)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,040,730,060.64** | **2,586,895,523.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **300,448,660.64** | **455,749,623.49** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 300,448,660.64 | 455,749,623.49 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 300,448,660.64 | 455,749,623.49 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 162,477,200.00 | 176,605,100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 137,971,460.64 | 279,144,523.49 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,740,281,400.00** | **2,131,145,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,617,317,500.00 | 2,024,948,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,617,317,500.00 | 2,024,948,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 122,963,900.00 | 106,197,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 122,963,900.00 | 106,197,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,920,817,413.91** | **2,596,340,753.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,920,817,413.91** | **2,596,340,753.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,856,908,601.43** | **2,536,490,787.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,404,451,105.24 | 1,979,900,864.04 |
| 210101 | Үндсэн цалин | 881,165,969.07 | 1,035,569,443.59 |
| 210102 | Нэмэгдэл | 456,542,028.97 | 823,247,657.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 54,111,071.98 |
| 210104 | Урамшуулал | 66,743,107.20 | 66,972,690.84 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 171,083,012.59 | 238,220,045.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,336,561.83 | 162,142,169.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,686,836.69 | 19,140,621.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,843,211.35 | 9,602,192.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,843,211.35 | 9,467,012.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,373,191.37 | 37,868,048.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58,100,787.52 | 75,771,333.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,337,360.38 | 40,373,549.47 |
| 210302 | Түлш, халаалт | 32,156,433.99 | 23,159,373.34 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,606,993.15 | 12,238,411.06 |
| **2105** | **Нормативт зардал** | 33,296,785.00 | 18,639,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,296,785.00 | 18,639,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,005,000.00 | 29,650,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,005,000.00 | 29,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,103,454.08 | 29,435,635.63 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 5,374,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,103,454.08 | 24,060,935.63 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 142,868,457.00 | 164,873,909.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,263,657.00 | 152,561,609.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,604,800.00 | 12,312,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,908,812.48** | **59,849,966.13** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,045,700.00 | 59,074,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,390,500.00 | 59,074,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,655,200.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 863,112.48 | 775,666.13 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 863,112.48 | 775,666.13 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **119,912,646.73** | **(9,445,230.20)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **73,918,300.00** | **68,348,096.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **73,918,300.00** | **68,348,096.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 73,918,300.00 | 68,348,096.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 73,918,300.00 | 68,348,096.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(73,918,300.00)** | **(68,348,096.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 45,994,346.73 | (77,793,326.20) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 288,967,573.03 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 288,967,573.03 | 211,174,246.83 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **397,920,000.00** | **4,621,121,827.79** | 5,019,041,827.79 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **397,920,000.00** | **4,621,121,827.79** | 5,019,041,827.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | 21,248,296.00 | 21,248,296.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **397,920,000.00** | **4,642,370,123.79** | 5,040,290,123.79 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | 47,071,250.02 | 47,071,250.02 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **397,920,000.00** | **4,689,441,373.81** | 5,087,361,373.81 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,964,906,100.00 | 2,627,217,287.58 | 337,688,812.42 | 88.61 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,964,906,100.00 | 2,627,217,287.58 | 337,688,812.42 | 88.61 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,874,179,600.00 | 2,536,490,787.58 | 337,688,812.42 | 88.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,090,979,600.00 | 1,979,900,864.04 | 111,078,735.96 | 94.69 |
| 210101 | Үндсэн цалин | 1,156,240,200.00 | 1,035,569,443.59 | 120,670,756.41 | 89.56 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 891,314,800.00 | 823,247,657.63 | 68,067,142.37 | 92.36 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 54,111,071.98 | (54,111,071.98) | |
| 210104 | Урамшуулал | 43,424,600.00 | 66,972,690.84 | (23,548,090.84) | 154.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 261,372,400.00 | 238,220,045.04 | 23,152,354.96 | 91.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 177,733,300.00 | 162,142,169.30 | 15,591,130.70 | 91.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,909,800.00 | 19,140,621.80 | 1,769,178.20 | 91.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,454,900.00 | 9,602,192.66 | 852,707.34 | 91.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,454,900.00 | 9,467,012.54 | 987,887.46 | 90.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 41,819,500.00 | 37,868,048.74 | 3,951,451.26 | 90.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 76,547,000.00 | 75,771,333.87 | 775,666.13 | 98.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,196,300.00 | 40,373,549.47 | (18,177,249.47) | 181.89 |
| 210302 | Түлш, халаалт | 44,254,000.00 | 23,159,373.34 | 21,094,626.66 | 52.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,096,700.00 | 12,238,411.06 | (2,141,711.06) | 121.21 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,001,500.00 | 18,639,000.00 | 3,362,500.00 | 84.72 |
| 210502 | Хоол, хүнс | 22,001,500.00 | 18,639,000.00 | 3,362,500.00 | 84.72 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,650,000.00 | 29,650,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,650,000.00 | 29,650,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 35,412,400.00 | 29,435,635.63 | 5,976,764.37 | 83.12 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,375,000.00 | 5,374,700.00 | 300.00 | 99.99 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,037,400.00 | 24,060,935.63 | 5,976,464.37 | 80.10 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 358,216,700.00 | 164,873,909.00 | 193,342,791.00 | 46.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 347,226,400.00 | 152,561,609.00 | 194,664,791.00 | 43.94 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,990,300.00 | 12,312,300.00 | (1,322,000.00) | 112.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 90,726,500.00 | 90,726,500.00 | - | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 90,726,300.00 | 59,074,300.00 | 31,652,000.00 | 65.11 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 90,726,300.00 | 59,074,300.00 | 31,652,000.00 | 65.11 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,946,406,100.00 | 2,586,895,523.49 | 359,510,576.51 | 87.80 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,024,948,900.00 | 2,024,948,900.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,024,948,900.00 | 2,024,948,900.00 | - | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 106,197,000.00 | 106,197,000.00 | - | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 106,197,000.00 | 106,197,000.00 | - | 100.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 815,260,200.00 | 455,749,623.49 | 359,510,576.51 | 55.90 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 82,978,500.00 | 176,605,100.00 | (93,626,600.00) | 212.83 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 448,628,700.00 | 279,144,523.49 | 169,484,176.51 | 62.22 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 283,653,000.00 | | 283,653,000.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **288,967,573.03** | (288,967,573.03) | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **211,174,246.83** | (211,174,246.83) | |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | хувь |
|---|---|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 106,197,000.00 | 105,421,333.87 | 775,666.13 | 99.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 106,197,000.00 | 105,421,333.87 | 775,666.13 | 99.27 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 76,547,000.00 | 75,771,333.87 | 775,666.13 | 98.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,196,300.00 | 40,373,549.47 | -18,177,249.47 | 181.89 |
| 210302 | Түлш, халаалт | 44,254,000.00 | 23,159,373.34 | 21,094,626.66 | 52.33 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,096,700.00 | 12,238,411.06 | -2,141,711.06 | 121.21 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,650,000.00 | 29,650,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,650,000.00 | 29,650,000.00 | 0.00 | 100.00 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 106,197,000.00 | 105,421,333.87 | 775,666.13 | 99.27 |
| 131001 | Орон нутгийн төсвөөс | 106,197,000.00 | 105,421,333.87 | 775,666.13 | 99.27 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Завсрын аудитаар сургалтын төлбөрийг НББ-ийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." НББ бодлогын баримт бичгийн 5.8 "Орлого хүлээн зөвшөөрөлт хэсэгт Ирээдүйд үзүүлэх үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг үйлчлүүлэгчээс урьдчилан хүлээн авсан бол бүтээгдэх үйлчилгээг бодиттой нийлүүлэх хүртэл орлогоор хүлээн зөвшөөрөхгүй" заасны дагуу 81,975.0 мянган төгрөгөөр авлага үүсгэн залруулах бичилт хийсэн.

Аудитаар нийт 85,445.3 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1,710.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, тогоочийн нэр төрлийн тайлан хийгдээгүй, хоолны нөхөн олговортой холбоотой 30,679.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 53,055.5 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант онд сургуульд элсэн суралцах хүсэлтэй 146 сурагчаас ямар нэгэн тушаал шийдвэргүйгээр 1,710.0 мянган төгрөгийн элсэлтийн хураамж авсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний нэр төрлийн тогоочийн тайлан гаргалгүйгээр худалдан борлуулах зорилгоор 28,004.8 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 45,946.2 мянган төгрөгийн хоол борлуулсны орлогыг харилцах дансандаа төвлөрүүлсэн, бага ангийн 8 багш, 1 хоол зүйч хоолны нөхөн олговор авсан хэдий ч 2,675.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоолонд хамрагдсан зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тодруулга тайлантай холбоотой асуудал

***<u>Илрүүлэлт</u>:***

Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-т "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025-01-03-ны өдрийн А/3 тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврыг зөрчсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

***Өгсөн зөвлөмж***:

Санхүүгийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Жилийн эцсийн санхүүгийн тайланд 16,162.5 төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж***:

Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх.

3. Тайлагналтай холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Тайлант онд журамд зааснаар 81 хүүхэд 13,400.0 мянган төгрөгийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Төлбөрийн орлогыг орлогот авахдаа хөнгөлөлтийг хассан дүнгээр орлого авснаас хөнгөлөлтийн дүн зардалд тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Орлогын ангилал хэсэгт "Сургалтын төлбөрийн буцаалт хөнгөлөлт" заасан заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:***

Хөнгөлөлтийн орлогын бүртгэлийг НББББ баримтын дагуу бүртгэж байх.

4. Худалдан авалттай холбоотой асуудал

***Илрүүлэлт:***

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 5,293.0 мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журмын 3.9-д заасан ".Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна"

***Өгсөн зөвлөмж:***

Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Уран-Эгшиг сургууль | 1 | 81,975.0 | | | 1 | 81,975.0 | 1 | 81,975.0 | | | | |
| Дүн | **1** | **81,975.0** | | | **1** | **81,975.0** | **1** | **81,975.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт-ны тоо | Тоо | Дүн |
| Уран-Эгшиг сургууль | 6 | 61,952.3 | 1 | 1,710.0 | 2 | 30,679.8 | 3 | 29,562.5 | | | | |
| Дүн | **6** | **61,952.3** | **1** | **1,710.0** | **2** | **30,679.8** | **3** | **29,562.5** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Уран-Эгшиг сургууль | 1 | 23,493.0 | | | | | 1 | 23,493.0 |
| Дүн | **1** | **23,493.0** | | | | | **1** | **23,493.0** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Уран-Эгшиг сургууль | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалз |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |